



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2026 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 1 хуулийн этгээдийн “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх” болон “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” тусгай зөвшөөрлийг тус тус 90 хоногийн хугацаатай түдгэлзүүлсүгэй.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

М.БАТТУЛГА


Ч.ЗОЛБАЯР

Б.МЯГМАРНАРАН

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2026 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн
74 тоот тогтоолын
хавсралт



Тусгай зөвшөөрлийн хугацааг 90 хоногоор түдгэлзүүлсэн
хуулийн этгээдийн жагсаалт

№	Хуулийн этгээдийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дуусах хугацаа	Эрхлэх үйлчилгээ, хамрах хүрээ
1	Өвөр даваат ХХК	13400104	2026.08.30	Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх, Өмнөговь аймаг
		23400071	2026.08.30	Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах Өмнөговь аймаг, Цогтцэций сум

----- оОо -----